

БҮРТГЭВ  
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ ХАЛАМЖИЙН  
АСУУДАЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН Ч.ОЮУНМАНДАХ  
2022 оны ..... сарын ..... өдөр

## БАЯНГОВЬ СУМЫН ТАМГЫН ГАЗАР ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ 2022 ОНД БАЙГУУЛАХ ХАМТЫН ГЭРЭЭ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль болон Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай Монгол улсын хуулиудыг үндэслэн хөдөлмөрийн харилцааг зохицуулах, ажлын чанар үйлчилгээ болон албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор энэхүү гэрээг байгуулав.

1.2. Хамтын гэрээ нь ажиллагчдын хөдөлмөрлөх эрх түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр хангах болон хуулиар шууд зохицуулагдаагүй бусад харилцааг зохицуулах хууль эрхийн баримт бичиг мөн.

1.3. Энэхүү гэрээг мөрдөгдөж эхэлснээс өмнө байгуулагдсан бүх хөдөлмөрийн гэрээний заалтуудад түүний нэмэлт өөрчлөлт оруулах буюу шинэчлэн байгуулна.

1.4. Хамтын гэрээний заалтуудаас илүү нөхцөлүүдээр байгуулагдсан хөдөлмөрийн гэрээний заалтууд хэвээр мөрдөгдөнө.

### ХОЁР: Ажил эрхлэлт ажлын байрны баталгааны талаар

2.1. Ажил олгогч нь ажил үйлчилгээг тасралтгүй хэвийн явуулах нөхцөл бүрдүүлж албан хаагчдыг ажиллах нөхцөлөөр бүрэн хангана.

2.2. Ажилчдыг ажлаас халах асуудлыг ҮЭ-ийн хороотой хамтран зөвшилцөн хуулийн хүрээнд шийдвэрлэнэ.

2.3. Ажил олгогч нь ажилтны эрүүл мэндийн байдал, хүсэл сонирхол шаардлагын улмаас эзэмшсэн мэргэжил, дадлага туршлага, ур чадварыг харгалзан ажлын байрыг өөрчилж болно.

### ГУРАВ: Цалин хөлсний талаар

3.1. Хөдөлмөрийн тухай хуулийн 109.6 дахь заалтыг үндэслэн ажилтанд үндсэн ажлынхаа зэрэгцээ 1 сараас дээш хугацаанд эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн бол 40% ээлжийн амралтаас бусад тохиолдолд тухайн ажилтны үндсэн тарифт цалингаас тооцон тус тус нэмэгдэл олгоно.

3.2. Бусад нэмэгдлийг хууль тогтоомжийн дагуу олгоно.

3.3.Ажлын үр дүнг харгалзан ур чадварын нэмэгдлийг жолооч, үйлчлэгч, архив бичиг хэргийн эрхлэгч, мэдээлэл технелогийн ажилтан, нягтлан бодогч, биеийн тамирын арга зүйч, няравт сар бүр 20-25%-иар олгоно.

**ДӨРӨВ: Ажил, амралтын цаг, чөлөө олгох**

4.1.Ажил олгогч нь албан хаагчиддаа дор дурьдсан хугацаагаар цалинтай чөлөө олгоно.

4.1.1.Албан хаагч хуримаа хийсэн бол ажлын 5 хоног

4.1.2.Хүүхэд нь хуримаа хийсэн бол ажлын 3 хоног

4.1.3.Эхнэр төрсөн бол ажлын 10 хоног

4.1.4.Эцэг эх, төрсөн ах, дүү гэр бүлийн хүн нас барвал ажлын 5 хоног

4.1.5.Хамаатан садангийн хүн нас барсан бол ажлын 3 хоног

4.1.6.Дээд шатны эмнэлэгт үзлэг шинжилгээ хийлгэхэд 7 хоног

4.1.7.Дээрх заалтуудаас бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар ажилтанд ажлын 5 хоногийн чөлөө 2 удаа олгоно.

4.2.Ажилтны гаргасан өргөдлийг харгалзан цалингүй чөлөөг олгоно.

**ТАВ: Хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах.**

5.1.Ажил олгогч нь ҮЭХ-той хамтран ажлын байрны үзлэгийг жил бүр явуулна. Ажилтаныг осол , мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, шаардлагыг ханган ажиллуулна.

5.2.Байгууллагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны бус ажилтан ажиллуулна.

5.3.Ажил олгогч нь ажилтаныг түүний хөдөлмөрийн нөхцөл ажил үүргийн онцлогт тохируулан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаадлагад нийцсэн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангана.

-Халдварт өвчин гарсан тохиолдолд түүнд дайчлагдах албан хаагчдад

-Жолооч, үйлчлэгч, нярав нарт ажлын тусгай иж бүрэн хувцасыг 2 жилд нэг удаа олгоно.

**Зургаа : Ажилчдын мэргэжил, мэдлэгийг дээшүүлэх**

6.1.Албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх, ур чадварыг нэмэгдүүлэх сургалтанд хамруулна.

6.2.Төрийн албан хаагчийг бакалавар,болон мэргэшүүлэх зэрэг урт богино хугацааны сургалтанд хамрагдвал үндсэн цалинг олгоно.

6.3.Ажлын байран дээрх сургалтыг тасралтгүй хуваарийн дагуу чанартай явуулна.

6.4.Хууль эрх зүйн мэдлэг олгох сургалтыг ҮЭХ-оос жилд 2–оос доошгүй удаа явуулна.

### **Долоо: Нийгэм ахуйн хөнгөлөлтийн талаар**

7.1.Цалингийн зардалаас хэмнэлт үүссэн бол үндсэн албан хаагчдад хоолны мөнгийг ажлын хоногоор тооцон өдрийн 4,000-10,000 төгрөгөөр бодож олгоно.

7.2.Байгууллага хамт олныг жилд 1удаа идэвхитэй амралт зохион байгуулахад байгууллагаас 400,000 төгрөг, ҮЭХ-оос 300,000 төгрөгийг олгоно.

7.3.Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор ковидын дараах нөхөн сэргээх эмчилгээг хийлгэх зардалд Үйлдвэрчний эвлэлийн хорооноос ҮЭХ-ний гишүүн тус бүрд нь 100,000 төгрөгийг олгоно.

7.4. Байгууллагын бүх ажилчдыг жилд 1удаа төвлөрсөн газарт үзлэг шинжилгээнд бүрэн хамруулж үзлэгийн төлбөрийг, ҮЭХ-оос гаргана.

7.2.Албан хаагчдад дараах тохиолдлуудад буцалтгүй тусламж олгоно.

7.2.1.Ажилтан нь салбарын тэргүүний ажилтан, төрийн одон медалиар шагнуулсан тохиолдолд, мөн удаан хугацаагаар өвдсөн тохиолдолд байгууллагаас 150,000, ҮЭХ-оос 130,000 төгрөг

7.2.2.Ажилтан нь байгууллагын болон сумын аварга болсон бол байгууллагаас 150,000, ҮЭХ-оос 100,000 төгрөг

7.2.3.Эхнэр, нөхөр, аав, ээж,үр хүүхэд нь нас барвал байгууллагаас 200,000 төгрөг ҮЭХ-оос 150,000

7.2.4.Төрсөн ах, эгч, дүү, хадам аав, ээж нас барвал байгууллагаас 150,000 төгрөг, ҮЭХ-оос 130,000 төгрөг

7.2.5.Ажилтаны гэр орон байгалийн аливаа гамшиг, гэнэтийн аюулд нэрвэгдсэн бол 200,000 төгрөг ҮЭХ-оос 150,000 төгрөг

7.2.6.Ажилтан өөрөө болон үр хүүхэд нь хуримаа хийвэл 150,000 төгрөг, ҮЭХ-оос 130,000 төгрөг

7.2.7.Аймаг, улсын чанартай уралдаан, тэмцээнд амжилт гарган байр эзэлсэн бол 150,000 төгрөг, ҮЭХ-оос 130,000 төгрөг

7.2.8.Төрсөн аав, ээж үр хүүхэд, эхнэр, нөхөр хүнд өвчилсөний улмаас асрамжилсан бол эмнэлгийн тодорхойлолтыг үндэслэн цалинтай чөлөө, 100,000 төгрөгний тусламж бусад тохиолдолд цалингүй чөлөө олгоно.

7.2.8.Тухайн байгууллагад ажиллаж байсан ахмад настангуудад ахмадын баяраар жилд 1 удаа хүндэтгэл үзүүлнэ.

7.2.9.Байгууллагын албан хаагч өвдөн дээд шатны эмнэлэгт эмчлүүлж байгаа тохиолдолд байгууллагаас 150,000 төгрөг ҮЭХ-оос 130,000 төгрөг олгоно.

7.2.10.Олон улсын хүүхдийн баяраар байгууллагын албан хаагчдын 0-16 насны хүүхдүүдэд баярын бэлгийг өгнө. 50 хувийг албан байгууллага, 50 хувийг албан хаагчдаас гаргана.

7.2.11.Байгууллагын ҮЭ –ийн хороонд татвараа төлдөг албан хаагчдыг дүрэмт хувцастай болгоход ҮЭХ-оос дэмжлэг үзүүлнэ.

**Найм: ҮЭ, түүний ажилтан сонгуультнаас үйл ажиллагаа явуулах  
нөхцөл бололцоог хангах**

8.1.ЗДТГ нь ҮЭХ-д хамтын гэрээний төсөл боловсруулах, хэлэлцээ хийх болон бусад үйл ажиллагаа явуулахад шаардагдах санхүү, эдийн засгийн холбогдолтой мэдээ тайлан, шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

8.2.Үндсэн ажлаасаа чөлөөлөгдөөгүй ҮЭ-ийн сургалтанд хамрагдах, хурал семинар ярилцлагад оролцох үед албан тушаалыг хэвээр хадгалж, дундаж хөлсийг олгоно.

8.3.Гишүүдийн хөдөлмөрлөх эрх түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг нь хөндсөн аливаа шийдвэрийг гаргахдаа 7 хоногоос багагүй хугацааны өмнө ҮЭХ–нд танилцуулж саналыг тусгаж байна.

8.4.ҮЭ-ийн гишүүдийн татварыг тооцсон цалингийн 1 хувиар бодож цалингаас сар бүр бэлэн бусаар хураана.


8.5.Байгууллагын ажилчид нь дундын санг үүсгэн байгуулж, сар бүр 10,000 төгрөгийг бэлэн бусаар хураан авч, хуримтлал үүсгэнэ.

**ЕС: Хамтын гэрээний хугацаа, биелэлтэд хяналт тавих, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах**


9.1.Энэхүү гэрээг батлагдсан хугацаанаас хойш 1 жилийн хугацаанд мөрдөгдөнө.

9.2.Хамтын гэрээний биелэлтийг ажил олгогч, ҮЭХ –той хамтран хагас бүтэн дүгнэж албан хаагчдад мэдээллэнэ.

9.3.Хоёр тал өөрт байгаа гэрээний хэрэгжилттэй холбоотой бүх мэдээллийг тогтмол солилцох үүрэг хүлээнэ.

Ажил олгогчыг төлөөлж  
ЗДТГ-ын дарга  Д.Отгонжаргал

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ҮЭХолбооны ажилтнуудыг төлөөлж  
ҮЭХ-ны тэргүүлэгч  Э.Пүрэвжаргал  
Б.Мөнхтогтох  
Д.Батжаргал